

Стандарт дахь нэр томъёоны бүтцэд хийсэн тоон шинжилгээ

Түвдэндоржийн БАТБЯМБА*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Хэрэглээний хэл шинжлэлийн салбар; БНХАУ,
Өвөр Монголын их сургууль, Монгол судлалын дээд сургууль

Received: Oct 4, 2023

Revised: Nov 24, 2023

Accepted: Dec 15, 2023

Хураангуй: ШУА-ийн ХЗХ-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарт хэрэгжүүлж буй “Монгол нэр томъёоны стандартын судалгаа (Нэр томъёог боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах)” суурь судалгааны төслийн хүрээнд Монгол Улсад хэрэглэж буй 10421 стандартчилсан нэр томъёоны сан бүрдүүлэв. Бидний цуглуулсан сан дахь 10421 нэр томъёо нь 1-13 үгээс бүтсэн байна. Стандартчилсан нэр томъёоны бүтцийг судлах нь нэр томъёо товч тодорхой, салаа утгагүй бөгөөд оновчтой байх гэсэн нэр томъёоны үндсэн шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой юм. Иймд уг судалгаа, ажиглалтдаа тулгуурлан, стандарт дахь нэр томъёоны бүтцийн талаар өөрсдийн саналаа нэмэрлэхийг зорив.

Түлхүүр үг: нэр томъёоны стандарт, бүрэлдэхүүн, нэр томъёо оноох боловсруулах зарчим, хэлний хэмнэл

Quantitative Analysis on Terminology Structure in Terminology Standards

BATBYAMBA Tuvdendorj

Department of Applied Linguistics, the Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia; the School of Mongolian Studies,
Inner Mongolia University, Hohhot, China

Abstract: The article deals with the structure of the terms in the standards based on the database of 10421 standardized terms created by the Sector of the Applied Linguistics, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences in the framework of the basic research project “Research on Mongolian term standards (Localization of international standards of terminology development methods and

* © Т.Багбямба
Email: batbyamba_t@mas.ac.mn

principles)”. *The 10421 terms in our database are made up of 1-13 words. Examining the structure of a standardized term is useful in determining whether the term meets the basic requirements of being concise, unambiguous, and rational. Therefore, based on the research and observations, we aimed to contribute our own suggestions about the structure of standardized terms.*

Keywords: *terminology standards, structure, principles of creating terms, language abbreviation*

1. Удиртгал

Орчин цагийн монгол хэлний үгийн сангийн чухал бүрэлдэхүүний нэг болсон нэр томъёог бүтцийн талаас нь тусгайлан судлах хэрэгтэй юм. Учир нь, монгол нэр томъёонд тавигддаг гол шаардлага нь товч тодорхой, оновчтой байх юм. 1740-1742 онд зохиогдсон *Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг* номд суурилсан нэр томъёо орчуулах, оноох, тогтоох, боловсруулах, жигдлэх ажил нь тасралтгүй үргэлжилсээр орчин цагтай золгожээ. Тухайлбал, сүүлийн үед нэр томъёоны онолын чиглэлээр *Монгол хэлний нэр томъёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж* (Гэрэлмаа, 2020), *Нэр томъёоны орчуулга судлал* (Мөнхцэцэг, 2020), *Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томъёо* (Шинэбаяр нар, 2020) зэрэг нэг сэдэвт бүтээл нэр томъёо оноох, боловсруулах талаар *Нэр томъёоны зүйл. 1. Орос-латин-монгол гурван нийцэт утгын ургамлын аймгийн нэрс* (1931), *Химийн ухааны зарим нэр томъёо* (1932), *Улсын нэр томъёоны комиссын мэдээ* (1950-1989), *Монгол орос нэр томъёоны толь I, II, III боть* (Нарангэрэл, 2021) зэргийг онцлон дурдаж болох ба хамгийн сүүлд олон салбарын эрдэмтэн судлаачдын хамтын хүчээр *Шинжлэх ухааны түлхүүр нэр томъёоны цахим тайлбар толь*-ийг боловсруулан, цахим орчинд байршуулж, сонирхсон хэн бүхэн ашиглах боломжийг олгожээ. Үүнд: байгалийн ухааны 5620, анагаах ухааны 1807, эрүүл мэндийн 1817, хөдөө аж ахуйн салбарын 1612, нийгмийн ухааны 1287 нэр томъёо болон хүмүүнлэгийн холбогдолтой 2081, инженерүүдийн голлон ашигладаг 154 үгийг багтаасан байна. Мөн 2023 оны 5 сард Монгол Улсын ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл болон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн хамтран *Нэр томъёоны цахим хуудас* /<https://terminology.mn/>-ыг ашиглалтад оруулжээ. Тус цахим хуудас нь 2023 оны 5 дугаар сарын байдлаар Монгол Улсын стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй хүчин төгөлдөр хэрэгжиж буй 6532 стандартаас 85 нэр томъёоны стандартыг сонгон авч нэр томъёоны тодорхойлолтуудыг түүвэрлэн нэгтгэж, толь бичгийн материалын санг бүрдүүлснийг англи, монгол цагаан толгойн дарааллаар танилцуулжээ.

Энэ мэтчилэн төрийн байгууллагуудын зүгээс нэр томъёоны стандарт болон нэр томъёог зөв оноох, тогтоох, орчуулах, боловсруулах, хэрэглэж хэвшүүлэх асуудлаар санал бодлоо солилцон, эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулж, олон өгүүлэл, нийтлэл бэлтгэн хэвлүүлж зохих үр дүнд хүрсээр байна. Гэвч нийтээр хэрэглэж буй нэр томъёоны стандартыг дахин хянах, улам боловсронгуй

болгох шаардлага байнга тулгардаг. Үүнд шинжлэх ухааны ул суурьтай, тооцоотой судалгаа хэрэгтэй юм. Иймээс бид өөрсдийн бүрдүүлсэн сандаа түшиглэн Монгол Улсын стандартууд дахь нэр томъёоны бүтцийг тодорхойлж, монгол хэлний хэм хэмжээнд хэр нийцэж буйд ажиглалт хийв.

2. Судалгааны арга зүй

Бид энэхүү судалгаандаа ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албатай хамтран бүрдүүлсэн Монгол Улсын аж үйлдвэр, нийтлэг үйлчилгээний салбарын 85 стандартын 10421 нэр томъёонд дараах алхам дарааллаар ажиглалт хийв. Үүнд:

1. Төрөлжүүлэн ангилах;
2. Цуглуулсан нэр томъёоныхоо бүтцийг тодорхойлох;
3. Зарим нэр томъёог дахин боловсруулах, оновчтой болгох талаар өөрсдийн саналыг дэвшүүлж, нэгтгэн дүгнэх зэрэг болно.

Судалгааны үр дүнг хавсралтаар үзүүлэв.

3. Төрөлжүүлэн ангилсан нь

Анхдагч нэр томъёоны санд боловсруулалт хийж, хэлний материалын сангаа байгуулав. Ингэхдээ хөмрөг хэл шинжлэлийн судалгаанд түгээмэл мөрддөг “Баталгаат, тэмдэглэгээт материалын сан”-д түшиглэсний сацуу задлан шинжлэх, харьцуулан үзэх, нэгтгэн дүгнэх, тоо бүртгэлийн зэрэг аргыг хэрэглэв.

Стандартчилсан нэр томъёоны санд буй үгээ *MNS ISO 9001: 2016 Чанарын менежментийн тогтолцоо Шаардлага*, *Чанарын удирдлагын тогтолцоо, MNS 6506: 2015 Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал нэр томъёо, MNS 0639: 2016 Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо, MNS 3473: 1983 Байгаль хамгаалал. Газар, Газар ашиглалтын нэр томъёо* зэрэг салбар тус бүрээр ангилж төрөлжүүлэв. Үүнд:

Хүснэгт 1. Стандартчилсан нэр томъёоны сан

Д/д	Стандартын дугаар	Салбар	Жишээ нь
1	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Бараа
2	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Борлуулагч
3	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Зах
4	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Минимаркет
5	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Супермаркет

6	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Үнэ
7	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Хайпермаркет
8	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Худалдагч
9	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Таглаа
10	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал	Таглаа

4. Цуглуулсан нэр томъёоныхоо бүтцийг тодорхойлсон нь

Бид судалгаандаа эх хэлний боловсруулалтад өргөн хэрэглэдэг “Онцлогийг тодорхойлох арга” (Attribute Description Method)-аар материалын сандаа тэмдэг хадсан бөгөөд стандартчилсан нэр томъёоны сангаа бүрдүүлэхдээ дэс дугаар, стандартын төрөл, стандартын дугаар, нэр томъёоны стандартын харьяалагдах салбарын нэр, стандартчилсан нэр томъёо, англи орчуулга, орос орчуулга, нэр томъёоны тодорхойлолт гэсэн найман зүйлээр ялган ангилав. Тус материалын сангийн сүүлийн хувилбар дээр стандартчилсан нэр томъёоны бүтцийн тоо (үгийн тоо) гэсэн баганыг нэмж, тохирох хэмжигдлийн үр дүнг тэмдэглэлээ.

Мөн материалын санд бүртгэгдсэн нэр томъёо нь хэдэн үгээс бүтсэнийг тооцоолохдоо зарим нэр үгийн тийн ялгал болон хамаатуулах зэрэг салангид бичигддэг нөхцөлүүд дээр тэмдэг хадаж, тооцооллыг $=IF(LEN(TRIM(B2))=0,0,LEN(TRIM(B2))-LEN(SUBSTITUTE(B2," ","")))+1$ томъёогоор гаргав.

Хүснэгт 2. Стандартчилсан нэр томъёоны бүтцийн тооцоолол

Д/д	Нэр томъёо /үгийн тоо/	Тоо	Хувь	Жишээ нь
1	Нэг	1249	12.02	Зах
2	Хоёр	3481	33.51	Их дэлгүүр
3	Гурав	2611	25.14	Бөөний худалдааны газар
4	Дөрөв	1447	13.93	Үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр
5	Тав	738	7.11	Гал түймэр унтраах даралтын хоолой
6	Зургаа	410	3.95	Хөөсөөр гал түймэр унтраах тээврийн хэрэгсэл
7	Долоо	298	2.87	Ашигт малтмалын ордыг ашиглах техникийн зураг төсөл
8	Найм	81	0.78	Ашигт малтмалын ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл
9	Ес	41	0.39	Ой, хээрийн түймэр унтраах хүнд даацын гинжит тээврийн хэрэгсэл

10	Арав	12	0.12	Бетон болон төмөр бетонон хийсэн цутгамал хийц эдлэхүүнд зориулсан хэв
11	Арван нэг	10	0.10	Ижил бус хөрөнгийг бүрэн эсвэл хэсэгчилсэн солилцоогоор худалдан авсан хөрөнгийн өртөг
12	Арван хоёр	8	0.08	Байршилтын хавтгайн тэнхлэг ба шулууны суурийн тэнхлэгтэй харьцангуй эгц босоо байх хэвийлт
13	Арван гурав	1	0.01	Гадсыг доргиулан эсвэл статик үйлчлэлээр зоох, сугалах шингэний удирдлагатай экскаватор дээр суурилсан төхөөрөмж
Нийт		10387	100	

Бүртгэлээс үзвэл, санд буй 10387 стандартчилсан нэр томьёо нь 1-13 үгээс бүтсэн байна. Үүнд, *агуулах дэлгүүр, төлбөрийн баримт, худалдааны талбай, цахим худалдаа, эвхдэг шат, аврах олс* гэх мэт хоёр үгээс бүтсэн 3481 нэр томьёо бүртгэгдсэн нь нийт сангийн 33.51 буюу хамгийн их хувийг эзэлж байна. Түүнчлэн санд *зүсэгч, тэлэгч, цоологч, тусгаарлагч, өргөгч, цөлжилт* гэх мэт дан үгээс бүтсэн нэр томьёо 1249 бүртгэгдсэн байгаа нь нийт сангийн 12.02 хувийг эзэлж байна. Энэ нь нийлмэл бүтэцтэй нэр томьёотой харьцуулахад дан бүтэцтэй нэр томьёо харьцангуй цөөн байгааг харуулж байна. Харин 10 ба түүнээс дээш үгээс бүтсэн *Хүхэрлэг бус газрын түүхий тос хүхэр багатай газрын түүхий тос, Өгөгдсөн чиглэл дэх тэгш хэмийн хавтгай эсвэл тэнхлэгийн байрлалын хүлцлийн талбай, Байршилтын хавтгай ба тэнхлэгийн суурийн тэнхлэгтэй харьцангуйгаар эгц босоо байх хүлцлийн талбай, Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх техникийн үзлэг үйлчилгээний төрлүүдийн хоорондох үйл ажиллагааны дундаж хугацаа* гэх мэт хэт урт нэр томьёо 31 гарсан бөгөөд нийт сангийн 0.30 хувийг эзэлж байна.

Тэгвэл дан үгээс бүтсэн стандартчилсан нэр томьёог тусгайлан авч үзье. Монгол хэл нь залгамал бүтэцтэй бөгөөд язгуурын араас дагавар залгаж үндэс үүсгэх, нөхцөл залгаж үг хувилгадаг онцлогтой. Энэ шинжийг шинэ үг бүтээх боломжийн талаас харахад нугалмал болон тусгайлаг хэв шинжийн хэлнээс хязгаарлагдмал байдалтай. Учир нь монгол хэлний үгийн язгуурын өмнө угтвар болон угтвар үгийг залган шинэ үг үүсгэдэггүйтэй холбоотой. Монгол хэлний бүтцийн онцлогоос хамаарч үг бүтээх түүнчлэн шинэ нэр томьёо бүтээх үндсэн арга нь язгуурт дагавар залгах нийлэг арга, хоёр өөр язгуур нийлж шинэ үг бүтээх задлаг арга гэдгийг судлаачид нэгэнт тогтоожээ.

Стандартчилсан нэр томьёоны сан дахь үгээ судлаач Г.Гэрэлмаагийн тодорхойлсноор нийлэг болон задлаг аргаар бүтсэн гэж хуваагаад нийлэг аргаар үүссэн үгэнд бас тоон судалгаа хийв. Бүртгэлээс үзвэл, 1249 дан үг, 9138 нийлэмж үг байна. Дан үгсийн 434 нь үндсээрээ, 516 нь дагаврын аргаар, 300 нь гадаад үг байна. Гадаад үгсийн 23 нь дагаврын аргаар, 277 нь үндсээрээ байна. Нийлмэл

үгийн бүтцийг үзвэл, дан монгол үгээс бүтсэн 9046, дан гадаад үгээс бүтсэн 30, холимог үг 62 байна.

Түүнчлэн нийлэг аргаар бүтсэн нэр томъёонд ашигласан шинэ үг бүтээх дагаврын тооцооллыг тусгайлан гаргавал:

-гч 72 /салаалагч, үлээгч, тэлэгч/

-лт 145 /хөрсжүүлэлт, тэсрэлт, цөлжилт/

-вч 13 /өвдгөвч, хаяавч, хошуувч/

-л 23 /чиглэл, гүйцэтгэл, ачаалал/

-аа 20 /ачаа, таглаа/ ~ -ээ 15 /сүлжээ/

-нги 3 /нуранги, татанги, алданги/

-ла 10 /ангилах, хамарлах, багцлах/

-лга 13 /асуулга, тодруулга, барилга/~ -лго 2 /овоолго/ ~ -лага 7 /хариуцлага, заслага, татлага/

-га 2 /давхарга/

-вар 3 /уулзвар, халдвар, найдвар/~ -вэр 4 /түүвэр, үйлдвэр, бичвэр/

-цар 2 /хавтанцар, буланцар/ ~ -цэр 3 /дүнзэнцэр, бүлэнцэр, тэргэнцэр/

-уур 14 /тулгуур, бутлуур, залгуур/

-үүр 11 /бүслүүр, хэмжүүр, шигшүүр/ гэх мэт болно.

Мөн санд буй монгол хэлний хэл зүйгээр хэлбэржсэн гадаад нэр томъёог ажиглавал:

-уул 4 /маркжуулах, капиталжуулах, автоматжуулах, компьютержуулах/ ~
-үүл 3 /индексжүүлэх, асфальтгүйжүүлэх, циклжүүлэх/

-лт 10 /индексжүүлэлт, тарифжуулалт, кодлолт, геокодлолт, изомержуулалт, коксжуулалт, алкилжуулалт, ароматжуулалт, полимержүүлэлт, фторжуулалт/

-чилол (-чил+л) 2 /кодчилол, роботчлол/

-лэг 1 /нивелирдлэг/

-д 1 /фрезердэх/ гэх мэт байна.

5. Дүгнэлт

Судалгааны ажиглалт, үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Стандартчилсан нэр томъёоны бүтцийг шинжилбэл 1-13 хүртэл үгээс бүтжээ. Тооны хувьд нэр томъёо товч бөгөөд тодорхой байх шаардлагад нийцэхгүй байгаа мэт боловч дурдсан байгалийн ухааны нэр томъёотой холбоотой ойлголт ухагдахуун монгол хэлэнд угаас байдаггүй тул тайлбарлан орчуулахаас аргагүй юм. Жишээлбэл: Англи хэлний “Mean

operating time between preventive servicing”, орос хэлний “Средняя наработка междувидами” гэсэн нэр томъёог монгол хэлэнд “Гадсыг доргиулан эсвэл статик үйлчлэлээр зоох, сугалах шингэний удирдлагатай экскаватор дээр суурилсан төхөөрөмж” хэмээн хэрэглэж байна. Эдгээр нэр томъёог мэргэжлийн салбарынхан товчлон хэрэглэж заншсан байж болох бөгөөд шинжлэх ухааны найруулга, мэргэжлийн бус хүмүүст ойлгуулахын тулд ийнхүү дэлгэрэнгүй тайлбарлан орчуулах аргыг ашигласан байна.

- Нэр томъёог оноож, тогтооход харьяалахын тийн ялгалын нөхцөл идэвхтэй хэрэглэгддэг нь ажиглагдаж байна. Тухайлбал: “Өгөгдлийн тоон дохионы хугацааны нэг төрлийн нэгтгэлт”, “Өгөгдлийн дохионы чанарын тоон детектор”, “Газрын тосны бүтээгдэхүүний зориулалтын савны хэмжилтэд хийх статистик шинжилгээ” гэх мэт. Иймд нэр томъёо бүхэн товч, тодорхой байна гэдэг шаардлага зарим орчуулгын нэр томъёоны хувьд өрөөсгөл болох нь харагдаж байна.
- Бидний хийсэн тоон шинжилгээнээс үзвэл, нийт 10387 стандартчилсан нэр томъёоны 330 нь дан гадаад үгээс бүтсэн бөгөөд нийт сангийн 3.18 хувийг эзэлж байна.

Ном зүй

- Гэрэлмаа, Г.** (2020). *Монгол хэлний нэр томъёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Gerelmaa, G. *Mongol helnii üg бүтэх задлаг хэв шинж*. Ulaanbaatar: Soyombo printing, 2020.]
- Мөнхцэцэг, Н.** (2020). *Нэр томъёоны орчуулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Munkhtsetseg, N. *Ner tomionii orchuulga sudlal* [Translation-Oriented Terminology]. Ulaanbaatar: Soyombo printing, 2020.]
- Мөнхцэцэг, Н.** (2015). Хэлний хэмнэх зарчим. *Хэл зохиол судлал, VIII (40)*, 68-78. [Munkhtsetseg, N. Principles of Language Economy. *Khel zokhiol sudlal*, 2015, VIII (40): 68-78.]
- Нарангэрэл, Н., Болд, Л., Өнөрбаян, Ц., Базаррагчаа, М., Гантогтох, Г., Баянсан, Ж., Санжаа, Ж., Самбуудорж, О., Заяабаатар, Д., Бямбацэрэн, Г., Жумдаан, Л., Баярсайхан, М., Пүрэвжав, Э., Түвшинтөгс, Б., Элбэгзаяа, Б., Энхтуяа, Л., Даваасүрэн, Т.** (2018). *Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь*. Улаанбаатар: Соёмбо хэвлэх үйлдвэр. [Narangerel, N., Bold, L., Ünürbayan, Ts., Bazarragchaa, M., Gantogtokh, G., Bayansan, J., Sanjaa, J., Sambuudorj, O., Zayabaatar, D., Byambatseren, G., Jumdaan, L., Bayarsaikhan, M., Pürevjav, E., Tüvshintugs, B., Elbegzaya, B., Enkhtuya, L., Davaasüren, T. *Mongol helnii zöv bichih дүрмийн журамласан толь* [Orthographic Dictionary of Mongolian Language]. Ulaanbaatar: Soyombo printing, 2018.]

Хавсралт


1. Дан бүтэцтэй үгсийн тооцоолол

Д/д	Стандартын дугаар	Салбар	Нэр томъёо	Бүтэц (Дан, нийлмэл)	Бүрэлдүүлбэр (монгол, гадаад, холимог)	Үндсээрээ эсэх
1	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал нэр томъёо	Үнэ	1	1	1
2	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал нэр томъёо	Зах	1	1	1
3	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал нэр томъёо	Таглаа	1	2	-гч
4	MNS 6506: 2015	Худалдааны үйлчилгээ, Худалдааны газрын ангилал нэр томъёо	Цохиур	1	2	-уур
5	MNS 0639: 2016	Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж бол он тээврийн хэрэгслийн нэр томъёо	Тариф	1	3	1
6	MNS 0639: 2016	Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо	Тариф-жуулалт	1	4	-лт

2. Нийлмэл бүтэцтэй үгсийн тооцоолол

Д/д	Стандартын дугаар	Салбар	Нэр томьёо	Бүтэц (Дан, нийлмэл)	Бүрэлдүүлбэр (монгол, гадаад, холимог)
1	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Хоолойн гүүр	2	1
2	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Хоолойн нөхөөс	2	1
3	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Хоолойн бэхэлгээ	2	1
4	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Хоолойн дамар	2	1
5	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Хоолойн хамгаалалт	2	1
6	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Хөөс холигч	2	1
7	MNS 0515: 2015	Шуудан холбооны нэр томьёо	Блок марк	2	3
8	MNS 5242: 2003	Нягтлан бодох бүртгэлийн нэр томьёо	Дижитал анализ	2	3
9	MNS 5242: 2003	Нягтлан бодох бүртгэлийн нэр томьёо	Цалин хөлс	2	1
10	MNS 5242: 2003	Нягтлан бодох бүртгэлийн нэр томьёо	Бүрдүүлэлтийн чанар	2	1
11	MNS 5242: 2003	Нягтлан бодох бүртгэлийн нэр томьёо	Бүртгэлийн тогтолцоо	2	1
12	MNS 1998-7: 2008	Газрын тосны аж үйлдвэрийн нэр томьёо	Хийн алдагдал	2	1
13	MNS ISO 20252: 2019	Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр томьёо	Даатгалын пломб	2	2
14	MNS ISO 20252: 2019	Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр томьёо	Дурсгалын марк	2	2

15	MNS ISO 20252:2019	Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр томъёо	Дурын код	2	2
16	MNS ISO 20252: 2019	Зах зээл, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа нэр томъёо	Купоны ноогдвор	2	2
17	MNS ISO 6701-1: 2010	Барилга ба иргэний барилга байгууламж	Тээвэрлэлтийн зай	2	1
18	MNS 5350: 2003	Цахилгаан станц. Цахилгаан шугам сүлжээ	Шүүрүүлгийн цооног	2	1
19	MNS 4673: 1998	Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа	Зорчигч дүүргэлт	2	1
20	MNS 6279: 2011	Ус хангамж, ариун цэврийн байгууламж	Тавцант хэв	2	1



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.